



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/6/СТА-ТТЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	7
2.8.2 Авлага	8
2.8.3 Бараа материал	8
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр.....	9
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
2.11. Шилэн дансны мэдээлэл	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3. Менежментийн захидал	13
3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	13
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.03.24 № 1/367

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Г БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА Г
Ж.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020795

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 451.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшинээс хэтэрч дүгнэлт өгсөн 4 байгууллагаас Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд "Сөрөг" санал дүгнэлт өгсөн. Мөн сумын ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зардлыг өмнөх оны үлдэгдлээс 118.4 сая төгрөгөөр санхүүжихээр буюу зардлыг эх үүсвэрээс нь 1.8 сая төгрөгөөр илүү баталсан.

Дээрх алдаа зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1. дэх "... энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2. дахь "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих Төсвийн тухай хуулийн 57 дугаар 57.3. дахь "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг зөрчиж санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Бууцагаан сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ж.Алтанцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 21-ээс 2020 оны 03 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэв.

Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1а/47 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Бууцагаан сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Бууцагаан сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Бууцагаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				Үүнээс: Гэрээгээр хийлгэсэн
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй	
1	Төсвийн шууд захирагч	4	6	-	-	2
2	ТБӨААН	-	-	-	-	-
	Дүн	4	6	-	-	2

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бууцагаан сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бууцагаан сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, гүйцэтгэлийн шатанд 1 эрсдэл нэмж сонгон, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5611.4 сая төгрөгийн 1.0 хувь буюу 5.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3828.6 сая төгрөгийн 1.0 хувь буюу 38.3 сая төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 10 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 1, “Хязгаарлалттай” 2 /Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль/, “Сөрөг” 1 /Засаг даргын Тамгын газар/ дүгнэлт өгч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, Баянбүрдийн бага сургууль, бага цэцэрлэг, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж санал дүгнэлт өгөөгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн дүгнэлтэд нөлөөлсөн гол зөрчлүүд.

Засаг даргын Тамгын газар:

1. Өмнөх оны буюу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
2. 2019 оны жилийн эцсийн тооллогын комисс томилогдсон тооллогын бүртгэлийг хийж, үр дүнг хэлэлцэж баталгаажуулаагүй.
3. Нягтлан бодогч нь нярвын тайланг сар бүр хянаж баталгаажуулдаггүйгээс нярвын тайлан, санхүүгийн тайлангийн бараа материалын орлого, зарлага зөрүүтэй, өр, авлагыг баталгаажуулаагүй байна.
4. Зочид төлөөлөгч хүлээн авах зардалд батлагдсан 9,1 сая төгрөгийг зарцуулахдаа зохих журмын дагуу тушаал шийдвэрийг гаргахгүйгээр зарцуулсан.

Дээрх алдаа, зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийнэ”, 18.2 дахь “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж мөрдөж ажиллах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллыг ашиглах зааврын 6 дугаар хавсралтын “Зочид төлөөлөгч хүлээн авах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн толилуулгын Үнэн зөв байх, Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдээдлүүдийг хангаагүй тул “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Эрүүл мэндийн төв:

1. Үндсэн хөрөнгийн дансны тээврийн хэрэгсэл, бараа материалын дансны тусгай зориулалтын материал, бусад хангамжийн материалын дансны тооллогын материал байхгүй, бичиг хэргийн материал зөрүүтэй тоологдсон.
2. Бараа үйлчилгээний бусад зардлаас 7500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлж, шууд зардлаар бүртгэсэн. Мөн хүнс, бусад хангамжийн материалын хоорондын тооцоонд 912.9 мянган төгрөгийн нэхэмжлэх зөрүүтэй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд Оршин байх, Эрх ба үүрэг, үнэн зөв гэсэн батламж мэдээдлүүдийг хангаагүй тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Ерөнхий боловсролын сургууль:

1. Тайлант онд “Их эффект” ХХК-ний 4150.0 мянга, “Ди Эн Констракшн” ХХК-д 9000.0 мянга, Баярнамд 7294.3 мянган төгрөгийг нэхэмжлэл, анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийсэн.

2. Цалингийн зардлаас байгууллагын даргын 2019.12.13-ны өдрийн А/30 тоот тушаалаар 15000,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар БНА-2020/6/СТА-ТТЗ

“Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт”-ын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил” гэсэн төсвийн зарлагын ангиллыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 51.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 49.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж 1.8 сая төгрөг зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас 49460.5 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд цэцэрлэгийн программ хангамжийн дансны үлдэгдлийг 400.0 мянга, үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл, өмнөх үеийн үр дүнг 2167.4 мянга нийт 2567.4 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд Соёлын төвийн бараа үйлчилгээний бусад зардлыг 368.6 мянга, Сум хөгжүүлэх сангийн зардлыг 3780.1 мянга, Эрүүл мэндийн төвийн төвлөрүүлэх шилжүүлгийг 39.7 мянга, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг Ерөнхий боловсролын сургууль 25806.9 мянга, бага цэцэрлэг 1211.1 мянга, цэцэрлэг 9651.3 мянган төгрөгөөр нийт 40857.7 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;

- Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд Бага сургуулийн бараа үйлчилгээний бусад зардлыг 200.0 мянга, Соёлын төвийн бараа үйлчилгээний бусад зардал, урсгал засварын зардлыг 2575.0 мянга, Засаг даргын Тамгын газрын хангамж бараа материалын зардал, албан томилолтын зардлыг 332.0 мянга, Эрүүл мэндийн төвийн бараа үйлчилгээний бусад зардал, төвлөрүүлэх шилжүүлгийг 2853.9 мянга, бага сургуулийн бараа үйлчилгээний зардлыг 74.5 мянган төгрөгөөр нийт 6035.4 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн;

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5.2 сая төгрөгийн залруулга хийлээ.

- Эрүүл мэндийн төвийн бараа үйлчилгээний бусад зардлаас анхан шатны баримтгүйгээр иргэн Л.Баярнямд 2019.12.26-нд 7500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба тус асуудал нь цагдаагийн эдийн засгийн албанд шалгагдаж байгаа гэсэн тайлбарыг нягтлан бодогч Д.Мөнхтуяа өгсөн ба санхүүгийн тайланд авлагаар тусгаж залруулга хийсэн.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 220.0 сая, эцсийн үлдэгдэл 67.3 сая төгрөг болж, 152.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	220.0	67.3	-152.7	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
Дүн	220.0	67.3	-152.7	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 67.3 сая төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 23.0 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 38.4 сая, Сум хөгжүүлэх сангийн дансанд 5.9 сая төгрөг байршиж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 23.0 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь орон нутгийн давсан орлогоос зарцуулагдаагүй 14.4 сая, төсөвт байгууллагуудын харилцах дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 7.6 сая, урьд оны зарцуулаагүй үлдэгдэл 1.0 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 202.2 сая, эцсийн үлдэгдэл 239.0 сая төгрөг болж, 36.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.0	1.4	0.4
Байгууллагаас авах авлага	34.1	4.2	-29.9
Хувь хүмүүсээс авах авлага	-	7.5	7.5
Зээлийн авлага	167.1	225.9	58.8
Дүн	202.2	239.0	36.9

Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны өмнөх оны үлдэгдэл тайлант онд 78.8 сая төгрөгөөр буурсан ч, тайлант онд сум хөгжүүлэх сангаас 98.5 сая төгрөгийн зээл олгож, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд хувь хүмүүсээс авах 7.5 сая төгрөгийн авлага үүссэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт №2.1. Авлагын үлдэгдэл байгууллагаар

/сая төгрөг/

Үзүүлэлт	Авлагын дүн	Үүнээс			
		Ажиллагчидтай холбогдсон авлага	Байгууллагаас авах авлага	Хувь хүмүүсээс авах авлага	Зээлийн авлага
Бага сургууль	0.0	0.0	-	-	-
Соёлын төв	1.0	1.0	-	-	-
Сум хөгжүүлэх сан	225.9	-	-	-	225.9
Засаг даргын тамгын газар	1.2	0.0	1.2	-	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.1	0.1	-	-	-
Эрүүл мэндийн төв	7.5	-	-	7.5	-
Ерөнхий боловсролын сургууль	3.1	-	3.1	-	-
Цэцэрлэг	0.1	0.1	-	-	-
Дүн	239.0	1.4	4.2	7.5	225.9

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 296.0 сая, эцсийн үлдэгдэл 412.6 сая төгрөг болж, 116.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	44.82	53.95	9.13
Эм боох материал	0.36	1.53	1.16
Бэлэн бүтээгдэхүүн	0.00	1.25	1.25
Бичиг хэргийн материал	5.33	9.48	4.15
Аж ахуйн материал	157.78	224.46	66.68
Сэлбэг хэрэгсэл	0.59	-	(0.59)
Түлш, шатах тослох материал	0.86	8.22	7.36
Барилгын засварын материал	0.78	7.33	6.55
Хүнсний материал	3.38	5.96	2.58
Бусад хангамжийн материал	65.85	100.46	34.62
Мал амьтад	16.21	-	(16.21)
Дүн	295.96	412.65	116.68

Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 395.0 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон Дэлхийн зөн ОУБ, БСШУЯ-ын хөрөнгө оруулалтаар 73.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 0.5 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авч 335.6 сая төгрөгийн бараа материал зарцуулан, 16.2 сая төгрөгийн бараа материал шилжүүлсэн байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 17719.0 сая, эцсийн үлдэгдэл 18017.3 сая төгрөг болж, 298.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	15,696.07	15,890.34	194.28
Тээврийн хэрэгсэл	311.27	325.53	14.26
Машин тоног төхөөрөмж	606.56	600.23	-6.33
Тавилга эд хогшил	334.66	350.48	15.81
Түүх соёлын дурсгалт зүйл	7.00	7.00	0.00
Дуусаагүй барилга байгууламж	506.82	506.82	0.00
Номын фонд	38.18	55.60	17.43
Бусад үндсэн хөрөнгө	36.79	100.66	63.87
Программ хангамж	20.08	19.09	-0.98
Бусад биет бус хөрөнгө	161.59	161.59	0.00
	17,719.01	18,017.34	298.33

Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 122.4 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 237.8 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 99.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, 98.3 сая төгрөгийн хөрөнгө акталж 39.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 23.6 сая төгрөгийн барилга байгууламж худалдсан байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 22.0 сая, эцсийн үлдэгдэл 4.2 сая төгрөг болж, 17.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	0.5	3.9	3.4	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	0.1	1.4	1.3	34.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	21.4	2.8	-18.7	65.9
Байгууллагад төлөх өглөг	0.5	0.0	-0.5	0.0
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-
Нийт дүн	22.0	4.2	-17.9	100.0

Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл нь Засаг даргын Тамгын газрын 2.2 сая, Эрүүл мэндийн төвийн 0.7 сая, Соёлын төвийн 0.3 сая, Бага сургуулийн 0.9 сая, Цэцэрлэгийн 0.1 сая төгрөгийн өглөг байна.

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6639.0 сая, эцсийн үлдэгдэл 6849.4 сая төгрөг болж, 210.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан Өмч /төрийн/	2132.3	2132.3	-	13.6
Хуримтлагдсан үр дүн	2132.3	2132.3	-	13.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10737.3	10346.6	-390.8	66.1
	3211.6	3179.9	-31.8	20.3
Дүн	16081.3	15658.8	-422.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны өөрчлөлт нь тайлант оны хуримтлагдсан үр дүн 423.1 сая төгрөгөөр буурч, Засаг даргын Тамгын газар, Цэцэрлэгийн өмнөх оны хуримтлагдсан элэгдлийг залруулсантай холбоотой өмнөх үеийн үр дүн 33.9 сая төгрөгөөр залруулсантай холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2019 оны төсөв батлах тухай 14/03 дугаар тогтоолд зааснаар Бууцагаан сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 6.5 сая, аймгийн төсөвт 121.0 сая нийт 127.5 сая төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 139.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	/сая төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	6.5	7.5	1.0	115.1
1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1.2	0.9	-0.3	76.8
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	4.0	5.4	1.4	135.3
1.3.Агаарын бохирдлын төлбөр	1.3	1.1	-0.2	88.1
2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	121.0	132.3	11.3	109.3
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	105.0	112.6	7.6	107.3
2.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.9	1.2	0.3	135.6
2.3.Газрын төлбөр	3.6	4.6	1.0	128.3
2.4.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	11.5	13.8	2.3	119.8
Нийт дүн	127.5	139.7	12.2	109.6

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 03 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 76.2 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 82.1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 152.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Сумын орон нутгийн орлого

Орлогын төрөл	/сая төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	65.2	77.0	11.8	118.04
ИОТХ	12.00	12.52	0.52	104.32
хадгаламжийн хүүгийн орлого	32.00	41.11	9.11	128.47
Бууны татвар	1.90	2.31	0.41	121.37
ҮХЭХ борлуулсны албан татвар	-	0.02	0.02	-
Улсын тэмдэгт	2.50	5.72	3.22	228.99
Бусад татвар	-	0.35	0.35	-
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	3.20	3.27	0.07	102.19
ТТАМАТөлбөр	0.30	0.30	-	100.00
Нохойны татвар	0.30	0.27	(0.03)	89.13
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	13.00	11.10	(1.90)	85.35
2.Татварын бус орлого	11.00	16.04	5.04	145.79
Хүү торгууль	11.00	16.04	5.04	145.79
Нийт дүн	76.20	93.00	16.80	122.04

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 3225.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2955.1 сая төгрөгийг урсгал зардалд, 222.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 830.2 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 1880.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 37.2 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 103.6 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 76.2 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 76.7 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 221.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аудитын илрүүлэлт:

• Бууцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн харилцах дансны өмнөх оны үлдэгдэл 116543.2 мянган төгрөг байхад сумын ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр тогтоолд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зардлыг өмнөх оны үлдэгдлээс 118363.1 мянган төгрөгөөр санхүүжихээр буюу зардлыг эх үүсвэрээс нь 1819.9 мянган төгрөгөөр илүү баталсан байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 830.2 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 1880.0 сая, орон нутгийн төсвөөс авах санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 103.6 сая төгрөгийг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 16.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 41.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 34.9 сая төгрөгөөр тасарсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлөлтийн орлогыг 34.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3130.3 сая төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь Эрүүл мэндийн төв, Бага сургуулийн хангамж бараа материалын зардал 4.0 сая, Эрүүл мэндийн төвийн норматив зардал 13.4 сая, Эрүүл мэндийн төвийн бараа үйлчилгээний бусад зардал 11.8 сая, Сум хөгжүүлэх сангаас тайлант онд 140.0 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 98.5 сая төгрөгийн зээл олгосонтой холбоотой бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 48.5 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 9. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	сая.төг	
			Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	350.5	345.5	5.0	98.6
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	71.8	70.7	1.1	98.5
Ерөнхий боловсролын сургууль	1207.1	1207.1	0.0	100.0
Цэцэрлэг	430.9	430.6	0.3	99.9
Эрүүл мэндийн төв	511.5	483.6	27.9	94.5
Соёлын төв	110.2	110.2	0.0	100.0
Орон нутгийн хөгжлийн сан	222.0	202.0	20.0	91.0
Сум хөгжүүлэх сан	140.0	99.2	40.8	70.8
Бага сургууль	129.3	129.1	0.2	99.9
Бага цэцэрлэг	52.3	52.3	0.0	100.0
Нийт дүн	3225.7	3130.3	95.4	97.0

Хөрөнгө оруулалтын 10 төсөл, арга хэмжээнд 222.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 202.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт төсөв: Төсөвт байгууллагууд нь дээд шатны төсвийн захирагчаас 66.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 4.7 сая нийт 70.8 сая төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлж ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 0.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 59.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 2.0 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан БНА-2020/6/СТА-ТТЗ

албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 9.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа

сая.төг

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт	Төвлөрүүлсэн	
			Аймаг	Сум
Засаг даргын Тамгын газар	42.90	42.79	-	0.11
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1.00	1.00	-	-
Соёлын төв	2.00	2.00	-	-
Эрүүл мэндийн төв	2.63	2.59	0.04	-
Сургууль	16.55	16.55	-	-
Цэцэрлэг	5.74	5.74	-	-
Нийт дүн	70.81	70.67	0.04	0.11

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

2.10.1. Эрүүл мэндийн төсвөөс иргэн Л.Баярнямд 2019.12.26-нд Бараа үйлчилгээний бусад зардлаас 7500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй "сургалтад" гэсэн гүйлгээг шилжүүлж тодруулахад Л.Баярнямаас тухайн 7500.0 мянган аймгийн ЭМГ-ын няравт бэлнээр өгсөн гэсэн тайлбар өгсөн. Дээрх асуудал нь цагдаагийн эдийн засгийн албанд шалгагдаж байгаа гэсэн тайлбарыг нягтлан бодогч Д.Мөнхтуяа өгөв.

Иймд дээрх 7500.0 мянган төгрөгийг авлагаар залруулсан бөгөөд тухайн асуудлын шийдвэрлэгдсэн байдлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

Аудитын илрүүлэлт:

• Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 451.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 31.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 306.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 105.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 7.5 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Бууцагаан сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 90 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээлэлд дахин завсар хийснээс хугацаа хоцроосон төлөвтэй болж 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	3	14	10	2	2
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	60		
5	Тухай бүр	5	60	59	1	
	Нийт	18	145	140	3	2

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Сумдын төсөвт байгууллагуудын санхүүжилтийн эрхийг нээхдээ Төсвийн тухай хуулийн дагуу сумын ИТХ-ын хуралдаанаар баталсан санхүүжилтээс илүү санхүүжилт олгож эрх нээдэг явдлыг таслан зогсоож, ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хугацаанд нь үнэн зөв нэгтгэж байх. Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан Улсын төсвийн НББ-ийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв нэгтгэж байх" гэсэн зөвлөмж өгснийг хэрэгжүүлж тайлант онд зөрчлийг давтан гаргаагүй байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бууцагаан сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Бууцагаан сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

3.1.1 Илрүүлэлт: Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 451.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль "Хязгаарлалттай", Засаг даргын Тамгын газар "Сөрөг" дүгнэлт авсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1. дэх "... энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2. дахь "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтыг зөрчсөн.

3.1.2 Эрсдэл: Төсвийн шууд захирагчийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Харьяа төсвийн байгууллагуудын төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, алдаа зөрчлийн давтан гаргуулахгүй байж, ТТЗ-ийн зүгээс төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж холбогдох албан тушаалтнуудын ажлыг дүгнэн, хариуцлага тооцож ажиллах.

3.2 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Бууцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн харилцах дансны өмнөх оны үлдэгдэл 116543.2 мянган төгрөг байхад сумын ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр тогтоолд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зардлыг өмнөх оны үлдэгдлээс 118363.1 мянган төгрөгөөр санхүүжихээр буюу зардлыг эх үүсвэрээс нь 1819.9 мянган төгрөгөөр илүү баталсан нь Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3. дахь "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж

хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл: Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөсөн төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсэх

3.2.3 Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга сумын ИТХ-д төсвийн төслийг өргөн мэдүүлж батлуулахдаа төсвийн нийт эх үүсвэр, зардлыг хянаж, тооцооллын алдаагүй төсөв батлуулж, хэрэгжүүлж ажиллаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	718095305.68	718986048.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	219969293.75	67315392.14
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	219969293.75	67315392.14
3121	Төгрөг	219969293.75	67315392.14
31211	Төрийн сангийн харилцах	219969293.75	67315392.14
33	АВЛАГА	202162966.52	239024073.61
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	950169.52	1351495.52
335	Бусад авлага	34099600.00	11739264.09
3351	Байгууллагаас авах авлага	34099600.00	4239264.09
3352	Хувь хүмүүсээс авах авлага		7500000.00
336	Зээлийн авлага	167113197.00	225933314.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	167113197.00	225933314.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	167113197.00	225933314.00
35	БАРАА МАТЕРИАЛ	295963045.41	412646582.41
351	Түүхий эд материал	45186179.00	55481459.00
35110	Тусгай зориулалттай материал	44821729.00	53954329.00
35130	Эм боох материал	364450.00	1527130.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3500.00	1253300.00
354	Хангамжийн материал	234563366.41	355911823.41
35410	Бичиг хэргийн материал	5333458.00	9484858.00
35420	Аж ахуйн материал	157781380.05	224460780.05
35430	Сэлбэг хэрэгсэл	585600.00	
35440	Түлш, шатах тослох материал	857700.00	8216091.00
35450	Барилгын засварын материал	780000.00	7327000.00
35460	Хүнсний материал	3379667.00	5958182.00
35470	Бусад хангамжийн материал	65845561.36	100464912.36
35600	Мал амьтад	16210000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15385235255.13	14943971605.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15385235255.13	14943971605.90
392	Биет хөрөнгө	15218743484.43	14780318585.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	15696066890.73	15890342046.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1467519598.88	-2191108237.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	311270500.00	325530500.00
